

**Нийгэм, улс төрийн салбарын үг хэллэгийн давтамж, шинэ үгийг
нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалсан нь**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Үрчгээгийн ШҮРЭЭ*

Монгол Улс, Улаанбаатар, Барилгын политехник коллеж,
Өвөр Монголын Их Сургуулийн МСДС-ийн докторант

Received: Apr 15, 2024

Revised: October 21, 2024

Accepted: November 04, 2024

Хураангуй: Шинэ үг хэллэг үүсэхдээ тэр хэлнийхээ үгийн сан хөгжин баяжих арга замаас гадуур үүсэх боломжгүй юм. Шинэ үг хэллэгийн шинэ байх хугацаа нь харилцан адилгүй бөгөөд найруулгын төрлүүдээс сонины найруулга нь үгийн сангийн өөрчлөлт хувьслыг өргөнөөр тусгаж байдаг тул өдөр тутмын сонины үгийн санд илэрсэн шинэ үг хэллэгийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалж, түүний хэрэглээний байдал, шинэ үгийн утгын баяжилт, нийгэмд шинэ үг үүсэх нөхцөл байдлыг судлах нь чухал юм. Иймээс Монгол Улсын өдөр тутмын сонин хэвлэлээс “Өдрийн сонин” сонины 2018.01.03, 2019.01.03, 2020.01.03-ны өдрийн гурван дугаараар цахим сан үүсгэв. Улмаар байгуулсан цахим сандаа тулгуурлан, улс төрийн салбарт үүссэн шинэ үгсийг түүвэрлэн, судалгааны сан бүрдүүлж, шинэ үгийн нийт тоо, давтамжийг тооцоолсны зэрэгцээ, шинэ үг хэллэгийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгааны үр дүнгээ энэхүү өгүүллээр танилцуулахыг зорив.

Түлхүүр үг: шинэ үг хэллэг, нийгэм хэл шинжлэл, цахим сан, үгийн давтамж, сонины үг хэллэг.

Research on New Words from a Sociolinguistic Point of View

SHUREE Urchgee

Construction Polytechnic College, Ulaanbaatar, Mongolia
Doctoral student of Inner Mongolian University, China

Abstract: New words can only be formed within the framework of a language's existing vocabulary. The lifespan of new words varies. For example, in the early 1990s,

* © Ү.Шүрээ, 2024
Email: shuree.u@cc.edu.mn

terms like “траншейны хүүхдүүд,” “нейжер,” “уймраа ногоон,” “цэцэг түүх,” “гэзгэг сүлжих,” and “ганзагын наймаачин” gradually fell out of use and are no longer in common usage today.

These changes in vocabulary are reflected in widely distributed daily newspapers, which cover various genres of writing. From a sociolinguistic perspective, the new vocabulary appearing in these newspapers can be studied to understand the usage and status of new words. This makes newspapers a valuable research tool for examining the enrichment of word meanings and the formation of new words in society.

In this context, we created an electronic database containing the vocabulary from newspaper issues sampled from daily newspapers published in Mongolia. Using this database, we calculated the total number of words and their frequency.

This article presents the results of research on new words in the state's discourse from a sociolinguistic perspective. The emergence of new words is important not only for the language but also for understanding societal progress, as well as developments in science and technology.

Keywords: electronic corpus, database, neologism, sociolinguistics, frequency

1. Удиртгал

Аливаа хэл тухайн нийгмийн хувирал, өөрчлөлтийг соргоогоор мэдэрч, тусган авч байдаг. Тэрхүү нийгмийн хувирал, өөрчлөлтийг өөртөө тусган авч, олон нийтэд түгээдэг зүйлсийн нэгд яахын аргагүй хэвлэл мэдээллийн хэрэгсэл ордог. Бид нийтлэлийн бодлогыг тодорхойлж, агуулгыг бэлтгэх болон хэвлэн нийтлэх үйл ажиллагааг эрхэлж байгаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэмээх ойлголтод бүх төрлийн радио, телевиз, сонин, сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудын эрхлэн гаргадаг мэдээ мэдээллийг багтаан ойлгож байна.

Хэвлэл мэдээллийн салбар нь нийгмийн амьдралд өрнөж буй үйл явдал, цаг үеийн мэдээ мэдээллийг хүний итгэл үнэмшил, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд тулгуурлан олон нийтэд түгээдэг билээ. Тийм учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэлэнд олон аргаар үүсэж байгаа шинэ үг хэллэгийг үндэсний аюулгүй байдлыг хангах, олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, олон ургалч үзлийг дэмжих, Монгол Улсын түүх, соёлын онцлогийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулах гэх зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр судлах шинжлэх ухааны ул суурьтай судалгаа зайлшгүй хэрэгтэй байна.

“Сонин хэвлэл нь зөвхөн мэдээлэх, дамжуулах, учир зүйн нотолгоо хийх төдийгүй сэтгэл зүйн хувьд нөлөөлөх үүрэгтэй бөгөөд бичлэгийн бусад төрлийг бодвол хэл найруулга энгийн, ойлгоход хялбар, цөөн үгээр, өргөн агуулга гаргадгаараа ялгарч байдаг” (Баттөгс ба бус, 2022: 286) хэмээжээ. Иймд сонины хэл найруулгад үг хэллэгийг зөв хэрэглэсэн эсэхийг тодруулахдаа хэлний үг хэрэглээний болон хэл зүйн хэм хэмжээнд тохирсон эсэх, мөн эх сурвалжийг анхаарах хэрэгтэй.

“Үг хэрэглээний хэм хэмжээ (lexical norm)-д хэн бүхэнд ойлгомжтой утгаар, нийтээр мэдэх нийлэмж үг хэллэгийг зөв сонгож, оновчтой зөв хэрэглэх явдлыг хамааруулж үздэг” (Пүрэвжав, 2020: 105) бол “Үг хэллэгийг ямар нэгэн салаа утгагүйгээр оновчтойгоор хэрэглэн, хэл яриаг зөв дамжуулж, ойлгуулахыг хэлний хэл зүйн хэм хэмжээ (grammar norm)-д багтаан үздэг байна” (Пүрэвжав, 2020: 105)

“Учир нь сонины хэл найруулга хүмүүсийн хэлний боловсролыг нь дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг тул түүний үг хэллэгийг монгол хэлний хэм хэмжээ гэжээ” (Пүрэвжав, 2020: 105), зөв бичих дүрэмд нийцүүлэх шаардлагатай байдаг. (Нарангэрэл ба бус, 2018).

Иймийн тул бид тухайн нийгмийнхээ бодит байдлыг хамгийн хурдан тусгаж, нийгэмд хүртээдэг өдөр тутмын сонин (нэр бүхий)-ы үгийн хэрэглээний байдал, үгийн утгын баяжилт, нийгэмд шинэ үг үүсэх нөхцөл боломж зэргийг судлан гаргахыг зорив.

2. Судалгааны арга зүй

Бид дээр дурдсан зорилгодоо хүрэхийн тулд иргэдийн хэрэглэж байгаа улс төрийн үг хэллэгийг өдөр тутмын сонины улс төрийн булангаас тодруулахыг зорьж, Өдрийн сонины 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн №001 (5844), 2019 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн №001 (6102), 2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн №001 (6360) дугаарын “Улс төр” булангийн нийт үгийн сангаар цахим сан үүсгэлээ. Уг санд тулгуурлан, цахим сан дахь үгийн санг бүртгэн, сан тус бүрийн давтамж болон тооцооллыг Antconc программ (Anthony, 2002), Excel Array Formula(=Filter(), hashtag) зэрэг томьёог ашиглан тооцож, шинэ үг хэллэгийг судалснаараа тус судалгааны бүтээл шинэлэг юм.

3. Үндсэн хэсэг

Нийгэм хэл шинжлэл нь хэлийг соёлын хэм хэмжээ, нөхцөл байдал зэрэг нийгмийн бүх талын нөлөөлөл, хэрэглэх арга зам, нийгэмд үзүүлэх нөлөөлөгч гэдэг талаас нь судлан шинжилж, тайлбарладаг салбар юм. Нөгөөтэйгөөр бүх шинжлэх ухааныг холбогч гүүр шинжлэх ухаан хэмээн ойлгож болно. Шинэ үг үүсэх үйл явц нь тухайн нийгмийнхээ толь учраас энэхүү хэлний үзэгдлийг хэлний нийгмийн талаас буюу нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь нэн чухал юм.

Нийгэм хэл шинжлэлийн үүднээс шинэ үг хэллэгийг судалсан судалгааны бүтээлүүд олон гарсаар байна. Тэдгээрээс Ш.Баттөгс (2004) *Орчин цагийн монгол хэлнээ шинэ үгийн судалгаа*, Д.Батнасан (2004) *Монгол хэлийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь*, Л.Нарантуяа (2013) *Шилжилтийн үеийн шинэ үг хэллэгийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь* нарын хэл бичгийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл, Э.Уранбилэг (2014) *Монгол хэлний шинэ үг бүтэх боломжийн тухайд* хэл бичгийн ухааны магистрын зэрэг горилсон бүтээл, Э.Уранбилэг (2014) *Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь*, *Хэл шинжлэл*

соёмбо нэвтэрхий толь (2012) зэрэг судалгааны бүтээлүүдийг дурдаж болно.

Монгол хэлний үгийн сангийн цахим сан байгуулах ажлыг өнгөрсөн зууны наяд оноос эхлэн Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл судлах газар “Монгол хэлний мэдээлэл боловсруулалт (mongolian information processing)-ын ажлаар эхлүүлсэн” (Насан-Урт, 2004: 3) бөгөөд энэ нь монгол хэлний үгийн сангийн хэрэглэгдэхүүнийг цуглуулан хадгалах, боловсруулах хялбар боломж олгосон. Түүнээс хойш гадаад, дотоодын төрийн болон хувийн хэвшлийн судалгааны байгууллагын багш, судлаачид эх хэл боловсруулахад зориулсан программуудыг зохиож, зохих үр дүнд хүрсээр байна.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Соёлын сайдын 2021 оны 07 сарын 30-ны өдрийн А/150 тоот тушаалаар батлагдсан “Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан” үүсгэх ажлын хүрээнд Монголын хуульчдын холбооны “Хуульчдын мэдээ” цахим сонин (www.mglbar.mn), Монголын Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “Хууль зүйн мэдээ” (nli.gov.mn) сонинуудын электрон хувилбаруудыг нээлттэйгээр байршуулж байгаа нь цахим санд суурилсан олон төрлийн судалгаа хийхэд ихээхэн үр өгөөжөө өгч байна.

Сонины үгийн санг хэрэглээний талаас нь судалсан судалгааны бүтээл¹ олон бий. Судлаач Ц.Сүхбаатар *Монгол хэлний найруулгын төрөл* (1990) хэмээх хамтын бүтээлийн *Сонины хэл найруулга* гэсэн хэсэгт 1920 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн *Монголын үнэн* сонин 637 буюу давтамжаараа 2563 үгтэй гэж тооцоолсон (Балдан, 2002: 63) байна.

Тиймээс тогтмол хэвлэл, тэр дундаа сонины үгийн санд бүртгэгдсэн шинэ үг үүсэх нөхцөл байдал, шинэ үг хэллэгийн хэрэглээ, шинэ үгийн утга баяжих үзэгдлийг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах найдвартай сурвалж болж чадна гэж үзэв.

¹ Сүхбаатар, Ц. (1998). *Монгол хэлний найруулга зүй*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн. (2002). *Хэл соёлын тулгамдсан асуудлууд №1*. Улаанбаатар: Бемби сан.
Пүрэвжав, Э. (2002). Монгол утга зохиолын хэлний хэл зүйн хэм хэмжээг сонины хэл найруулгад баримтлахын учир холбогдол. *Хэл соёлын тулгамдсан асуудлууд*, 1: 38-61.
Балдан, Л. (2002). Сонины хэл найруулгын бүтэц, тогтолцооны асуудал. *Хэл соёлын тулгамдсан асуудлууд*, 1: 62-80.
Болд, Л. (2002). Хүмүүс сонины нэгэн дугаарт найруулга зүйн үүднээс хийсэн судалгааны зарим дүн. *Хэл соёлын тулгамдсан асуудлууд*, 1: 80-106.
Лочин, С. (2002). Сонины гажигтай хэллэг ба зарим нэр томьёо. *Хэл соёлын тулгамдсан асуудлууд*, 1: 107-117.
Мөнхсайхан, С. (2002). Сонины хэл найруулгад харь үгийн үүрэг. *Хэл соёлын тулгамдсан асуудлууд*, 1: 140-155.
Баттөгс, Ш., Пүрэвжав, Э. Түвшинтөгс, Б., Гэрэлмаа, Г., Шинэбаяр, О., Ганболд, Д. (2022). *Үгийн сан, утга, найруулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг.
Шагдарсүрэн, Ц., Бадамдорж, Д., Самбуудорж, О., Пүрэвжав, Э., Баттөгс, Ш., Гэрэлмаа, Г. (2022). *Үгийн сан, утга зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

4. Үгийн сангийн давтамжийн тооцоолол

Аливаа хэлний бүх үгийг тухайн хэлний үгийн сан гэдэг (Баттөгс ба бус, 2022: 15) хэмээн тэмдэглэсэн байна. Иймээс бид сонины дугаар бүрийн бүх үгийг тухайн сонины үгийн сан хэмээн ойлгож, үгийн сангийн давтамжийн тооцооллыг гаргалаа. Давтамж гэдэг бол ямар нэгэн зүйл хэр олон удаа давтагдахыг хэлэх бөгөөд давтамжийн тооцоололд суурилан өгөгдлийн сангуудыг зохион байгуулах, онцлогийг тодорхойлох, үгийн сангийн идэвхтэй хэрэглэгдэж байгаа үг хэллэгийг тодруулах зэрэг үнэн бодит баримтад суурилсан судалгааны үр дүнг гаргах боломжтой байдаг.

Үг таних чадварт дүн шинжилгээ хийсний үр дүнд илэрч байгаа давтамжийн тооцоолол эх хэл боловсруулалтын үр ашгийг тодорхойлох хамгийн чухал зүйлийн нэг юм. Их давтамжтай үгсийг илүү олон хүн мэдэх боломжтой бөгөөд бага давтамжтай үгстэй харьцуулбал илүү богино хугацаанд хүмүүст хүрдэг онцлогтой. Гэсэн хэдий ч бага давтамжтай шинэ үг хэллэг олны анхаарлыг татах боломжийг тухайн баримт, мэдээнд олгодог талтай. (Monsell et al, 1989) хэмээжээ.

А. Цахим сангийн үгийн сангийн давтамжийн тооцоолол

Бид цахим сангаа Өдрийн сонины

- 2018.01.03 (2018 оны сан)-ны лхагва гарагийн №001 (5844) дугаар нийт 20 нүүр;
- 2019.01.03 (2019 оны сан)-ны пүрэв гарагийн №001 (6102) дугаар нийт 16 нүүр;
- 2020.01.03 (2018 оны сан)-ны баасан гарагийн №001 (6360) дугаар нийт 16 нүүртэй тухайн оных нь ууган дугааруудыг онцлон авч, бүрдүүлэн, үгийн сангийн давтамжийг тооцож гаргалаа.

Цахим сангуудад хийсэн тооцооллоо хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Цахим сангийн үгийн сан, түүний давтамж

№	Сонины нэр	Сонины дугаар	Давтагдаагүй нийт үгийн тоо	Давтагдсан үгийн тоо
1	Өдрийн сонин	2018.01.01, Лхагва, №001 (5844)	34837 үг	9301 үг
2	Өдрийн сонин	2019.01.03, Пүрэв, №001 (6102)	28287 үг	7806 үг
3	Өдрийн сонин	2020.01.03, Баасан, №001 (6360)	28431 үг	7823 үг

Дээрх хүснэгтээс үзвэл:

- 2018 оны сан давтагдаагүй тоогоор 34837, давтагдсан тоогоор 9301;
- 2019 оны сан давтагдаагүй тоогоор 28287, давтагдсан тоогоор 7806;
- 2020 оны сан давтагдаагүй тоогоор 28431, давтагдсан тоогоор 7823 үгтэй байна.

В. “Улс төр” булангийн үгийн сангийн давтамжийн тооцоолол

2018, 2019, 2020 оны Өдрийн сонины “Улс төр” булангийн үгийн сангийн тооцооллыг хийснээ доор танилцуулъя.

Үүнд:

- 2018.01.03 (2018 оны сан)-ны өдрийн лхагва гарагийн №001 (5844) дугаарын “Улс төр” булан нь давтагдаагүй тоогоор 5990, давтагдсан тоогоор 2647 үгтэй байна. Тус булангийн үгийн санг 2018 оны цахим сантай харьцуулахад, 17,19%-ийг;
- 2019.01.03 (2019 оны сан)-ны пүрэв гарагийн №001 (6102) дугаарын “Улс төр” булан нь давтагдаагүй тоогоор 6814, давтагдсан тоогоор 2917 үгтэй байна. Тус булангийн үгийн санг 2019 оны цахим сантай харьцуулахад, 24,08%-ийг;
- 2020.01.03 (2020 оны сан)-ны баасан гарагийн №001 (6360) дугаарын “Улс төр” булан нь давтагдаагүй тоогоор 6991, давтагдсан тоогоор 2843 үгтэй байна. Тус булангийн үгийн санг 2020 оны цахим сантай харьцуулахад, 24,23%-ийг тус тус эзэлж байна.

С. “Улс төр” булангийн хамгийн их давтамжтай үгсийн тооцоолол

Хүснэгт 2. Хамгийн их давтамжтай үгс

№	Өдрийн сонин 2018.01.03, Лхагва, №001 (5844)	Давталт	Өдрийн сонин 2019.01.03, Пүрэв, №001 (6102)	Давталт	Өдрийн сонин 2020.01.03, Баасан, №001 (6360)	Давталт
1	байна	131	байна	103	байна	120
2	юм	82	байгаа	78	байгаа	71
3	байгаа	80	юм	68	энэ	71
4	энэ	57	энэ	62	юм	61
5	бол	41	гэж	56	бол	58
6	л	34	л	50	гэж	57
7	гэж	31	байх	31	ч	53
8	ч	30	ч	29	л	51
9	ямар	28	бол	28	байсан	46
10	нэг	26	их	28	УИХ	39

Дээрх хүснэгтээс үзвэл, дээр дурдсан хамгийн их давтамжтай 10 үг нь 2018 оны өгөгдлийн сангийн 9.01%, 2019 оны өгөгдлийн сангийн 7.77%, 2020 оны өгөгдлийн сангийн 9.09%-ийг тус тус бүрдүүлсэн байна.

Цахим сангуудын хамгийн их давтамжтай үгсээс *байна* (354), *байгаа* (229), *юм* (221), *энэ* (190), *гэж* (144), *л* (135), *бол* (127), *ч* (112) гэсэн найман үг бүх санд

бүртгэгдсэн бол, *байсан* (46), *УИХ* (39), *байх* (31), *ямар* (28), *их* (28), *нэг* (26) гэсэн зургаан үг зөвхөн нэг санд илэрчээ.

Түүнчлэн олон давтагдаж байгаа үгсийн ихэнх нь “*бай-*” язгуурт үйл үг байна. Үүнийг бид үйл үг бол өгүүлбэр бүтээгч бөгөөд түүнгүйгээр утга санааг төгс илэрхийлэхэд хангалтгүй байдагтай холбож ойлгож байна.

а. Сонины үгийн сан дахь шинэ үг хэллэг

Бидний сонгож авсан сонины дугаарууд нь улиран одсон жилийнхээ ажлыг дүгнэсэн, ирж байгаа жилд бүтээн байгуулах ажлуудаа тоймлон танилцуулсан тухайн оныхоо онцгой цаг үеийн шинэ ухагдахуун, шинэ мэдээ мэдээллийг хэвлэсэн учир шинэ үг хэллэг олон байна.

Шинэ ухагдахууныг дагаж шинэ үг, шинэ нэр томьёо үүсдэг хуультай (Пүрэвжав, 2020: 105) гэжээ. Сүүлийн жилүүдэд болж өнгөрсөн онцлог хэрэг явдал, шинэлэг томьёоллоос үүдэж, *цүнх баригч, оффшорчид, саарал жагсаалт, эдийн засгийн чөлөөт бүс, бүсээ чангалах, цар тахал, ойрын хавьтал, хүн хоорондын зай, тусгай үүргийн нислэг* зэрэг шинэ үг, шинэ нэр томьёо монгол хэлэнд бий болжээ.

Сонины улс төрийн буланд бүртгэгдсэн шинэ үг хэллэгээс дурдвал:

- *чиглэл хүргүүлэх, ханиад томууны дэгдэлт, сэндвичэн барилга, автомат сануулга, баялаг бүтээгч, хөдлөх хөрөнгө өмчлөх, иж бүрэн автоматжих* гэх мэт 13 шинэ үг хэллэг 2018 оны цахим санд;
- *алтны лобби, төрөөс ангид байх, дэлхийн жишиг, хар жагсаалт, хаврын жагсаал, олигархуудыг дэмжих, фракцын хамгаалалт, байгальд ээлтэй технологи* гэх мэт 10 шинэ үг хэллэг 2019 оны цахим санд;
- *цүнх баригч, хөл хорио, масст хүргэх, виз чангарах, транзит нислэг, ковидын горим, бүсчилсэн хөгжлийн бодлого, мэргэшсэн албан хаагч* гэх мэт 17 шинэ үг хэллэг 2020 оны цахим санд бүртгэгдсэн байна.

2018 оны сонины “Улс төр” буланд “*Чингис бонд*”, “*Цалинтай ээж*” хөтөлбөр, “*Утаагүй зуух*”, “*Утаагүй түлш*”, “*Оффшор бүс*” зэрэг үг хэллэг бүртгэгдсэн нь улс төрчдийн мөрийн хөтөлбөртөө дэвшүүлсэн зорилтуудтай холбоотойгоор үүссэн гэж үзэж байна.

2019 оны сонины “Улс төр” буланд “*ЖДҮ*”, “*Хөзрөө дэлгэх*”, “*Мэрит*” зарчим, “*60 тэрбум*”, “*Алтны лобби*” зэрэг үг хэллэг бүртгэгдсэн нь хууль бусаар бий болгосон нууц хөрөнгийн асуудлыг тус оноос эхлэн сөхөж эхэлснээс гадна улс төрчдийн сонгуулийн сунгаа эхэлсэнтэй холбоотойгоор үүссэн гэж үзэж байна.

2020 оны сонинд титэм вирустэй холбоотой *тусгаарлалт, голомт, халдвар, covid-19, зөөвөрлөх, дархлаажуулалт, шинжилгээ, вакцин, коронавирус, сорьц* зэрэг үгс гарч байгаа нь дэлхий нийтийг цочроосон титэм вирусийн тархалт нэг жилийн турш үргэлжилсээр ирсэн түүхэн хар үйл явдалтай холбогдож байна. Энэхүү үр дүн нь сонины үгийн сан нийгмийн хувирал өөрчлөлтийг соргоогоор мэдэрдэг, хэлний хамгийн хөдлөнгө бөгөөд идэвхтэй салбар тул шинэ үг

хэллэгийн судалгаанд хамгийн тохиромжтой хэрэглэгдэхүүн гэдгийг харуулж байна.

Өөрөөр хэлбэл уг үзэгдэл нь судлаач Чэн Яан Мин, Чэн Зан Тай нарын “нийгэм хэл шинжлэл бол хэл болон нийгэм зэрэгцэн хувиралцах, хэл болон соёл зэрэгцэн орших үзэгдлийг судалдаг шинжилгээ мөн”² хэмээн дэвшүүлсэн саналтай нэгдэж байна.

б. Сонины үгийн сан дахь шинэ үг хэллэгийн бүрэлдүүлбэр

Цахим сангийн үгийн сан, давтамжийн тооцооллыг судалгааны үндсэн хэсэгт дурдсан тул энд бид цахим санд бүртгэгдсэн шинэ үг хэллэгийг бүрэлдүүлбэр хийгээд бүтэх аргын талаас авч үзсэнээ танилцуулж байна.

Үүнд:

Нэг үгээс бүтсэн:	<i>хаус, констракшин, андройд, лизинг, ложистик, молл, тауэр, спиртлэг, монополь, ёолкдох, сүлжээчин, конторлох, блансжих, төсөлчин;</i>
Хоёр үгээс бүтсэн:	<i>мөнгөний урсгал, ширхгийн материал, халдваргүйжүүлэлтийн горим, бохир өрсөлдөөн, хуулбар нам, хөзөр дэлгэх, тендер гаргуулах, бойкот үргэлжлэх, контакт гэрээ, мерит зарчим, ждүчин тонуулчид;</i>
Гурван үгээс бүтсэн:	<i>цогц хөрөнгө оруулалт, ашиг сонирхлын зөрчил, цахим санал асуулга, чиг үүргийг тодруулах, стратегийн түншлэлийн харилцаа, захиалгат дуудлагын үйлчилгээ, хулгайчийг бойжуулсан нийгэм;</i>
Дөрвөн үгээс бүтсэн:	<i>цүнх баригчдын боловсруулсан хууль, олон нийтэд хүртээмжтэй болгох, дэлхий нийтийн дүрмээр тоглох, том хөршүүдийн бөглүү булан, тусгай үүргийн шууд нислэг, ковидын хоёр дахь тархалт;</i>
Таван үгээс бүтсэн:	<i>сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалд, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэрэглэгчдэд итгэмжлэгдсэн шилдэг хамт олон, ил тод байдлын гэрээ хэлэлцээр, олон улсын тролл армийн дэмжлэг;</i>
Зургаан үгээс бүтсэн:	<i>хувийн ашиг сонирхлоос ангид байлгах зарчим, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил гэх мэт байна.</i>

Дээрхээс үзвэл, тус цахим санд бүртгэгдсэн шинэ үг хэллэг нь 1-6 үгээс бүрдсэн байна. Тооцооллын хувьд нэг үгээс бүтсэн 7, хоёр үгээс бүтсэн 10,

² Бадма-Одсэр, *Одоо үеийн хэл шинжлэлийн онолын сонгомол*, Хөх хот, 2012, 6 тал.

гурван үгээс бүтсэн 8, дөрвөн үгээс бүтсэн 6, таван үгээс бүтсэн 5, зургаан үгээс бүтсэн 2 шинэ үг хэллэг тус тус бүртгэгджээ.

с. Сонины үгийн сан дахь шинэ үг хэллэгийн бүтэх арга

Сонины цахим санд байгаа шинэ үг хэллэгийг бүтэх аргаар нь ангилахдаа Ш.Баттөгсийн ангиллыг (Баттөгс ба бус, 2022: 204) баримталлаа. Тухайлбал:

Шинэ үг бүтээх үндсэн арга:

1. Үг нийлэх арга:

- *Харь үг, уугуул үгтэй нийлж, шинэ үг бүтээх: масст хүргэх, виз чангарах;*
- *Үг + үг: улс төржилт, суурьшлын бүс, мөнгөний урсгал;*
- *Үг + нийлмэл үг: хувийн ашиг сонирхол, цогц хөрөнгө оруулалт;*
- *Нийлмэл үг + үг: улс төрийн томилгоо, байнгын ажиллагаатай парламент);*
- *Нийлмэл үг + нийлмэл үг гэсэн бүтцээр шинэ үг бүтээх: евро стандартын утлагын аппарат, төгрөг шалгагчтай мөнгө тоологч гэх мэт.*

2. Дагаврын аргаар шинэ үг бүтэх:

- *Язгуур үндсэнд дагавар залгаж шинэ үг бүтээх. (бүсчлэх, төсөлчин, томилгоо, ёолкдох, ждүчин, түншилэл);*
- *Харь үгэнд үйл үг бүтээх дагавар залгаж шинэ үг бүтээх. (лоббидох, бойкотлох, блансжих, монопольдох);*

3. Үгийн сан-утга зүйн арга:

- *Холбоо үгийн утга шилжисж, шинэ үг бүтээх.*
- *(6 хувийн зээл (ТОСК, 2022), хуулбар нам, хөзөр дэлгэх, тусгай үүргийн нислэг, захиалгат дуудлагын үйлчилгээ)*

Шинэ үг бүтээх туслах арга:

1. Харь үг ашиглах арга.

- *Олон улсын чанартай үг хэллэгийг хэвээр нь авч хэрэглэх. (монополь, лобби, бланс, статус, сенат, конгресс);*
- *Хуулбарлан орчуулах. (limit – хил хязгаар (www.bolor-toli.com), бартер. barter – бараа солилцооны тухай (www.bolor-toli.com), масс. mass – олонх, дийлэнх (www.bolor-toli.com);*
- *Харь үгийг монгол үгтэй нийлүүлэн холбоо үг бүтээх. (дижитал орчин, онлайн сүлжээ, ковидын тархалт, массын сэтгэл зүй, леги тоглоом);*

2. Үг товчилж, шинэ үг бүтээх.

- *ОУВС-Олон Улсын Валютын Сан, ЖДҮ-Жижиг Дунд Үйлдвэр, АТГ-Авлигатай Тэмцэх Газар, ШӨХТГ-Шударга Өрсөлдөөн Хэрэглэгчийн Төлөө Газар гэх мэт болно.*

Дээрх үгсийг ажиглахад **оффшордох**, **сошиалаар нийтлэх**, **олигархуудыг дэмжих** зэргээр харь хэлний үгсийг хэл зүйн хувиллаар хувилгаж, монгол хэлнээ нутагшуулан хэрэглэж байгаа нь шинэ үг хэллэг нь явцуу хэрэглээнээс өргөн хэрэглээний үг хэллэг болж байна. Мөн *хуулбар нам, хөзөр дэлгэх, тусгай үүргийн нислэг, захиалгат дуудлагын үйлчилгээ, ковидын горим, хувийн ашиг сонирхол, цогц хөрөнгө оруулалт* зэрэг нийгмийнхээ өөрчлөлт хөгжилтэй холбоотойгоор шинэ ухагдахуун үүсэж байгаа нь ажиглагдлаа.

5. Судалгааны үр дүн (хэлэлцүүлэг)

- Гурван сонины дугаараар нийт 91.555 үгтэй цахим сан байгуулж, дугаар тус бүрийн “Улс төр” булангаар цахим сан үүсгэж, үгийн санг тооцоолоход, давтагдсан тоогоор 19.715 давтагдаагүй тоогоор 8.411 үг бүртгэгдэв.
- Цахим сангууд дахь хамгийн олон давтамжтай 10 үг нь 2018 оны цахим сангийн 9.01%, 2019 оны цахим сангийн 7.77%, 2020 оны цахим сангийн 9.09%-ийг тус тус бүрдүүлжээ. Цахим сангуудын хамгийн их давтамжтай үгсээс *байна, юм, байгаа, энэ, бол, л, гэж, ч* гэсэн найман үг бүх санд бүртгэгдсэн бол, *байсан, УИХ, байх, ямар, нэг, их* гэсэн зургаан үг зөвхөн нэг санд илэрчээ.
- Бүрэлдүүлбэрийн хувьд 1-6 үгээс бүтсэн шинэ үг хэллэг бүртгэгдсэн бөгөөд 2 үгээс бүтсэн үг хамгийн их буюу 10 байна.
- Монгол хэлний үг бүтэх үндсэн болоод туслах аргуудаас сонины цахим санд бүртгэгдсэн шинэ үг хэллэгүүд үүссэн бөгөөд ялангуяа үг нийлэх арга болон үгийн сан-утга зүйн аргаар хамгийн идэвхтэй үүсжээ.

6. Дүгнэлт

Бид Өдрийн сонины 2018.01.03, 2019.01.03, 2020.01.03-ны өдрийн дугаарын “Улс төр” булангийн цахим санд тулгуурлан үгийн давтамжийн судалгааг хийж, шинэ үг хэллэгийг бүртгэн, бүрэлдүүлбэр, бүтэх аргын талаас судлан, дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

- Ийнхүү улс төрийн буланд нийтлэгдсэн мэдээ мэдээлэл нь бүрэн цахим сангийн 21.53%-ийг эзэлж байгаа нь Өдрийн сонины хувьд улс төрийн бодит үйл явдлыг хүргэхэд ихээхэн анхаарлаа хандуулж байгааг харуулж байна.
- Цахим сангууд дахь хамгийн олон давтамжтай 10 үгэнд улс төрийн үг хэллэгт тооцогдох *УИХ* гэсэн нэг л үг бүртгэж, бусад үг нь найруулгын бүх төрөлд хамаарагддаг үгс байна. Энэ нь тухайн мэдээг бичсэн нийтлэлчийн бичвэрийн бус Монгол хэлний өгүүлбэрийн олон янзын баймж утга илтгэдэг үгсийг түлхүү ашиглаж санаа бодлоо илэрхийлдэг найруулгын ерөнхий онцлогтой холбоотой байна.
- Онцлогийн хувьд дан үгээс бус нийлмэл аргаар бүтсэн үгс олон байгаа нь шинэ үг хэллэгийн илэрхийлж байгаа утга санаа нь өргөн бөгөөд гүн байгааг илтгэж байна.

- Сонины цахим санд тухайн цаг үеийн онцлогийг харуулсан шинэ үгс олон бүртгэгдэв. Тухайлбал, *оффшор бүсэд банкны данс эзэмших, оффшор данс эзэмшигч, оффшор бүсэд бүртгэлтэй хүмүүс, оффшор бүстэй холбоотой үйл ажиллагаа, оффшор бүс, оффшордох, оффшорчин* гэх мэт оффшор гэсэн үгтэй холбоотой үгсийг дурдаж болно. Энэ нь сүүлийн жилүүдэд оффшор гэх монголын нийгэмд үүсээд байгаа далд улс төрийн үйл явцыг илтгэсэн үгийн хэрэглээ ихэссэнийг илэрхийлж байна.

Судлаач Чэн Яан Мин, Чэн Зан Тай нарын дэвшүүлсэн саналын дагуу авч үзвэл энэ чиглэлийг хэл, соёлыг хамтад нь судлах судалгааг олон шинжлэх ухааны уулзварт хийх нь ихээхэн ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Ном зүй

- Балдан, Л.** (2002). Сонины хэл найруулгын бүтэц, тогтолцооны асуудал. *Хэл соёлын тулгамдсан асуудлууд* 1:62-80. [Baldan, L. On the Issues of Structure and System in Newspaper Stylistics. *Hel soyoliin tulgamdsan asuudluud*, 2002, 1: 62-80.]
- Баттөгс, Ш., Пүрэвжав, Э. Түвшинтөгс, Б., Гэрэлмаа, Г., Шинэбаяр, О., Ганболд, Д.** (2022). *Үгийн сан, утга, найруулга судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Battögs, Sh., Pürevjav, E., Tüvshintögs, B., Gerelmaa, G., Shinebayr, O. Ganbold, D. *Ügiin san, utga, nairuulga sudlal* [Lexicology, Semantics, Stylistics]. Ulaanbaatar: Soyombo printing. 2022.]
- Нарангэрэл, Н., Болд, Л., Өнөрбаян, Ц., Базаррагчаа, М., Гантогтох, Г., Баянсан, Ж., Санжаа, Ж., Самбуудорж, О., Заяабаатар, Д., Бямбацэрэн, Г., Жумдаан, Л., Баярсайхан, М., Пүрэвжав, Э., Түвшинтөгс, Б., Элбэгзаяа, Б., Энхтуяа, Л., Даваасүрэн, Т.** (2018). *Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь*. Улаанбаатар: Соёмбо хэвлэх үйлдвэр. [Narangerel, N., Bold, L., Ünürbayan, Ts., Bazarragchaa, M., Gantogtokh, G., Bayansan, J., Sanjaa, J., Sambuudorj, O., Zayabaatar, D., Byambatseren, G., Jumdaan, L., Bayarsaikhan, M., Pürevjav, E., Tüvshintugs, B., Elbegzaya, B., Enkhtuya, L., Davaasüren, T. *Mongol helnii zöv bichih dürmiin juramlasan toli* [Orthographic Dictionary of Mongolian Language]. Ulaanbaatar: Soyombo printing. 2018.]
- Насан-Урт, С.** (2004). *Монгол хэл бичгийн сураг занги боловсруулах онол практикийн зарим асуудал*. Улаанбаатар: Адмон принтинг. [Nasan-Urt, S. *Mongol hel bichgiin surag zangi bolovsruulah onol praktikiin zarim asuudal* [On the Some Issues of Theory and Practice in Processing Electronic Corpus of Mongolian Language and Script]. Ulaanbaatar: Admon printing. 2004.]
- Пүрэвжав, Э.** (2020). *Монгол хэлний хэм хэмжээ судлал*. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Pürevjav, E., *Mongol helnii hem hemjee sudlal*. [Studies on Norm of Mongolian Language]. Ulaanbaatar. 2020.]

Anthony, L. (2002). <https://www.laurenceanthony.net/software/antconc/>. Retrieved from Laurence Anthony's AntConc: <https://www.laurenceanthony.net/software/antconc/>
Monsell, S., Doyle, M. C., Haggard, P. N. (1989). Effects of frequency on visual word recognition tasks: Where are they? *Journal of Experimental Psychology: General*: Retrieved from <https://doi.org/10.1037/0096-3445.118.1.43>

Ашигласан хэрэглэгдэхүүн

Төрийн орон сууцны корпораци. (2022).

Retrieved from <https://tosk.gov.mn/?p=6322>

Энхцэг. (2021.03.26). “Ипотекийн 6 хувийн зээл, орон сууцжуулах хөтөлбөр зэрэг салбарын цаг үеийн асуудлаар мэдээлэл хийлээ.

Цахим холбоос

www.bolor-toli.com. (n.d.).

http://www.bolor-toli.com/dictionary/word?authenticity_token=tB1KhICZ1WyGlCaHuE1HNvTTUzeDPHYz97Uhob8Nw34%3D&selected_lang=4-1&search=limit

www.bolor-toli.com. (n.d.).

http://www.bolor-toli.com/dictionary/word?search=barter&selected_lang=4-1&see_usages=undefined&see_variants=undefined

www.bolor-toli.com. (n.d.). Retrieved from http://www.bolor-toli.com/dictionary/word?search=mass&selected_lang=4-1&see_usages=true&see_variants=true


www.bolor-toli.com. (n.d.). Retrieved from <http://www.bolor-toli.com>: http://www.bolor-toli.com/dictionary/word?search=mass&selected_lang=4-1&see_usages=true&see_variants=true

<https://doi.org/10.1037/0096-3445.118.1.43>

<https://www.mglbar.mn/news/3007>

https://nli.gov.mn/?page_id=8513

<http://toli.gov.mn/r>



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.